



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01/М

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Дамдинпүрэвээс аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.4, 25.1.5, 25.1.6, 25.1.7, 25.1.8 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Г.Лхагватахан нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА